



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар

16/03

Номгон

Аймгийн 2019 оны төсвийн хавсралтын
зарим зардалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19.1, 18.1.2-ын “б”, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус XVI хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн 2019 оны орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих утааг бууруулах ажлын хүрээнд Баянхонгор сумд цахилгаан халаагуураар иргэдийг хангах ажлыг ангилагдаагүй зардалд шилжүүлж хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төсөвт багтаан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ХҮИ
хуралдааны 16/03 дугаар тогтоолын хавсралт



**АЙМГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙН ХАВСРАЛТЫН
ЗАРИМ ЗАРДАЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ЖАГСААЛТ**

/төгрөг/

№	ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН	ХАСАХ	НЭМЭХ
1	Утааг бууруулах ажлын хүрээнд Цахилгаан халаагуураар иргэдийг хангах /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/	100 000 000,0	
	Санхүүжүүлэх эх үүсвэр		
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	100 000 000,0	
	АНГИЛАГДААГҮЙ ЗАРДАЛ		
2	Утааг бууруулах ажлын хүрээнд Цахилгаан халаагуураар иргэдийг хангах /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/		100 000 000,0
	Санхүүжүүлэх эх үүсвэр		
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		100 000 000,0
	НИЙТ ДҮН	100 000 000,0	100 000 000,0

_____ооо_____